

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2021 оны 11 дүгээр сарын 02-ний өдөр

1. Монголросцветмет” ТӨҮГ нь Хэнтий аймаг, Бор-Өндөр суманд “Бор-Өндөр” Уулын баяжуулах үйлдвэрийн ажилчдын 230 айлын амины болон нийтийн орон сууцны хотхоны барилга, инженерийн шугам сүлжээ, гадна тохижилтын зураг, геодез, геологийн судалгаа, төсөв, зөвшөөрлийн зардал хийлгэх гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Хэнтий аймаг, Бор-Өндөр суманд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 11 дүгээр сарын 30–ны өдрийн 09 дугаар тогтоолоор тус сумын 2 дугаар баг Тахилгат овооноос төмөр зам хүртэл нутаг дэвсгэрт амины орон сууцны зориулалтаар олгосон 56328 м² газар дээр “Бор-Өндөр” Уулын баяжуулах үйлдвэрийн ажилчдын 230 айлын амины болон нийтийн орон сууцны хотхон барихаар чанар стандартын шаардлага хангасан материалаар хийж гүйцэтгэх барилга, инженерийн шугам сүлжээ, гадна тохижилтын зураг, геодез, геологийн судалгаа, төсөв, зөвшөөрлийг боловсруулна.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
 - Барилгын зураг төслийн инженерийн шугам сүлжээ, гадна тохижилтын зураг, геодез геологийн судалгаа, төсөв /техник, эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв/ хийж гүйцэтгэх дараах холбогдох тусгай зөвшөөрлүүд /2022 оны 6 дугаар сарыг дуустал хугацаанд хүчинтэй байх шаардлагтай/, үүнд:
 - Архитектур, барилга бүтээцийн зураг төсөлтэй холбоотой бусад холбогдох тусгай зөвшөөрлүүд
 - Барилга угсралтын ажлын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ,АГТ, ҮЗБТ) хийж гүйцэтгэх тусгай зөвшөөрөл,
 - Барилга байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв хийж гүйцэтгэх тусгай зөвшөөрөл,
 - Бүс нутаг, хот суурингийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөөнд зориулан явуулах инженер геологийн дунд, том масштабын зураглал, инженер-гидрогеологи, инженер-геологи, инженер геозкологийн суурь судалгаа хийж гүйцэтгэх тусгай зөвшөөрөл.
 - Байгууллагын ерөнхий танилцуулга,
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/,
 - Зөвлөх хуулийн этгээдийн санхүүгийн чадавхийн мэдээлэл /сүүлийн 2 жилийн буюу 2019, 2020 оны санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх/,
 - Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ ирүүлнэ,
 - 2019, 2020 онуудад хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2021 оны 11 дүгээр сарын 15–ны өдрийн 12 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 12 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.
5. Тендерийг 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 12.10 цагт цахимаар нээнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ

Хаяг: Улаанбаатар хот 51, ш/х – 002

Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө.

22-р хороо, “Монголросцветмет” ТӨҮГ-ын байр, 402 тоот,

И-мэйл: mailbox@monros.mn.

Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-458675, 976-11-450060-186